

БАТЛАВ
ТӨРИЙН НАРИЙН БИЯГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХОЁРДУГААР ҮЕ ШАТАНД
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах газар нэгж, албан тушаалтан
Нэг. Шудрага, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилгыг хангах чиглэлээр				
1	4.1.1.1. төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх	1. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэгт /ХАСУМ/ хавсарган илгээх баримт бичгийн жагсаалтад Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг оруулах 2. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод болгох	2021 2021	ТЗУГ, ЭБАТ ТЗУГ, ЭБАТ
2	4.1.1.2. нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх	3. Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлагыг батлах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор ажлын байрны тодорхойлолтуудыг шинэчлэх	2021	Бүх газар, хэлтэс
3	4.1.1.7. нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	4. Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	2021	ТЗУГ, ХШУДАГ, ЭБАТ

3	4.1.1.9. төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл боломжийг сайжруулах	5. Албан хэрэг хөтлөлтийн ABLE цахим системийг ашиглан бусад Төрийн байгууллагуудтай холбогдох боломжийг бүрэн ашиглах	2021	ТЗУГ
4	4.1.1.10. нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх	6. АТГ-ын Олон нийтийн төвд зохион байгуулагдах бүх сургалтад албан хаагчдыг жигд оролцуулах	2021	ТЗУГ, ЭБАТ
		7. УУХҮЯ-ны албан хаагчдын 2021 оны сургалтын төлөвлөгөөнд Авилгын эсрэг болон төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг төлөвшүүлэх бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалтуудыг тусган батлуулах, төлөвлөгөөний дагуу сургалтуудыг зохион байгуулах	2021	ТЗУГ, ЭБАТ
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
5	4.1.2.1. төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	8. төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийг үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах	2021	ТЗУГ
		9. Яамны цахим сүлжээнд авилгын эсрэг төлөвлөгөөг байршуулах, санал, сэтгэгдэл хүлээж авах боломжийг бүрдүүлэх	2021	ТЗУГ, ХШУДАГ
6	4.1.2.4. эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох	10. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	2021	ТЗУГ, ХШУДАГ
Гурав. Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
7	4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	11. Яамны санхүүгийн зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд “ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл” гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх	2021	ТЗУГ, СХ
Арав. Шудрага ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авилгын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
9	4.1.10.1. авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн	16. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор иргэдэд зориулсан сургалт сурталчиггааны ажлыг зохион байгуулах	2021	ТЗУГ, бүх газар хэлтэс

	бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	17. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлан, мэдээг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлэх	2021	ТЗУГ, ЭБАТ
Яамны эрхлэх ажлын хүрээнд				
10	Давхар ажил эрхлэх боломжтой эсэхийг шийдвэрлэх	18. Хуулиар болон бусад холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрээр зөвшөөрөгдсөн давхар эрхэлж болох ажлын жагсаалтыг гаргаж албан хаагчдад танилцуулах	2021	ТЗУГ, ЭБАТ
		19. Давхар ажил эрхэлж байгаа ажилтны судалгааг гаргаж, АТГ-д хүргүүлэх	2021	ТЗУГ, ЭБАТ